

БОЛОВСРОЛЫН ЧИГЛЭЛЭЭР:



БОЛОВСРОЛЫН ЧИГЛЭЛЭЭР 2014 ОНД ХИЙГДСЭН АЖИЛ:

Сургуулийн өмнөх боловсол:

Ховд аймгийн хэмжээнд 2014-2015 оны хичээлийн жилд төрийн өмчийн 28, хувийн өмчийн 11 нийт 39 цэцэрлэгийн өдрийн 163 бүлэгт 5145 хүүхэд, хувилбарт сургалтын 52 бүлэгт 1348 хүүхэд хамрагдаж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан хүүхдийн тоо 377 буюу 6.2 хувиар өссөн байна.

Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт /бохир жин /

| Хичээлийн жил | Хамрагдвал зохих хүүхдийн тоо | Хамрагдсан хүүхдийн тоо | Хамран сургалтын хувь |
|---------------|-------------------------------|-------------------------|-----------------------|
| 2011-2012 | 7064 | 5811 | 82,3 |
| 2012-2013 | 7099 | 5998 | 84,4 |
| 2013-2014 | 7320 | 6116 | 83,6 |
| 2014-2015 | 7473 | 6493 | 86,9 |



Ерөнхий боловсролын сургууль:


Төрийн өмчийн ерөнхий боловсролын 24 сургуулийн 682 бүлэгт 17842 хүүхэд суралцаж байна.

Бага боловсролын хамран сургалт, /Цэвэр жин/

| Хичээлийн жил | Хүн амын тоо | Бага боловсролд хамрагдаж байгаа хүүхэд | Хамран сургалтын хувь |
|---------------|--------------|---|-----------------------|
| 2011-2012 | 10078 | 9435 | 93.6 |
| 2012-2013 | 9702 | 8656 | 89.2 |
| 2013-2014 | 7689 | 7538 | 98.0 |
| 2014-2015 | 8079 | 7819 | 96.8 |


Суурь боловсролын хамран сургалт /Цэвэр жин/

| Хичээлийн жил | ЕБС-д сурч байгаа 11-14 настай суралцагч | Өџі àì û í òî î | Хамран сургалтын хувь |
|---------------|--|-----------------|-----------------------|
| 2011-2012 | 6740 | 7656 | 88 |
| 2012-2013 | 5108 | 5579 | 91.6 |
| 2013-2014 | 5987 | 6477 | 92.4 |
| 2014-2015 | 5968 | 6339 | 94,1 |




2014-2015 оны хичээлийн жилд нэгдүгээр ангид 1875 хүүхэд элсэн орсон нь 2013-2014 оны хичээлийн жилийнхээс 185 хүүхдээр буюу 10.9 хувиар өсч, нийт суралцагчдын 10.5 хувийг эзэлж байна.

1 дүгээр ангид элсэн суралцагчид



Сургууль завсардалт:

2014-2015 оны хичээлийн жилд 16 хүүхэд сургууль завсардсан нь өмнөх оны хүүхдийн тооноос 18 хүүхдээр буурлаа.



2014-2015 оны хичээлийн жилд 17 дотуур байранд 1846 хүүхэд амьдарч, сурч хүмүүжиж байна.

| № | Үзүүлэлт | 2010-2011 | 2011-2012 | 2012-2013 | 2013-2014 | 2014-2015 |
|---|---------------------------------------|-----------|-----------|-----------|-----------|-----------|
| 1 | Дотуур байрны тоо | 18 | 19 | 19 | 19 | 17 |
| 2 | Дотуур байрны хүчин чадал | 1830 | 1860 | 1960 | 1960 | 2025 |
| 3 | Дотуур байранд хүсэлт гаргасан хүүхэд | 3040 | 2538 | 2774 | 1927 | 2075 |
| 4 | Дотуур байранд амьдарч байгаа хүүхэд | 2295 | 2060 | 1947 | 1846 | 1894 |
| 5 | Нийт ажиллагсад | 198 | 211 | 208 | 203 | 208 |
| 6 | Дотуур байрны багш | 28 | 27 | 26 | 27 | 29 |
| 7 | Дотуур байрны ажилтан | 170 | 184 | 182 | 176 | 179 |

Ерөнхий боловсролын сургуульд 2014-2015 оны хичээлийн жилд нийт 994 багш, 794 ажиллагчид ажиллаж байгаагийн 315 нь бага ангид, 389 нь дунд ангид, 290 нь ахлах ангид багшлаж, үндсэн багш нар нийт ажиллагчдын 55,6 хувийг эзэлж байна.

Ерөнхий боловсролын сургуульд ажиллаж байгаа багш нарын боловсролын түвшин /тоо/



“БАГШ СОЛИЛЦОО” ХӨТӨЛБӨР АМЖИЛТТАЙ ХЭРЭГЖИЖ БАЙНА



“Багш солилцоо-1, 2” арга хэмжээгээр нийт 20 багш, Монтессорийн арга зүйгээр цэцэрлэгийн багш нарыг солилцуулан ажиллуулж, БНСУ-д 2 багш, нийслэлийн 23 дугаар бүрэн дунд сургуулийн 10 багш, Жаргалант сумын 10 багшийг хооронд нь солилцооны хөтөлбөрт хамрууллаа.

БОЛОВСРОЛЫН САЛБАРТ АМЖИЛТ ГАРГАСАН БАГШ НАРАА УРАМШУУЛАВ

Монголын багш нарын 48 дахь өдрийг тэмдэглэж, Боловсролын салбарт хүүхэд нэг бүрийг хөгжүүлэхэд амжилт гаргасан багш нарыг 18,9 сая төгрөгийн мөнгөн шагналаар шагнаж урамшуулав.



АРДЫН ЯЗГУУР УРЛАГИЙН 1805 ХҮҮХДИЙН ТОГЛОЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



“Авьяас” хөтөлбөрийн хүрээнд Галдан бошигт хааны мэндэлсний 370 жилийн ойгоор Угсаатны бүлгүүдийн их наадмыг зохион байгуулж, уран нугаралтын чуулбар, домборын чуулга, 700 сурагчийн найрал дуу, 100 хүүхдийн хөөмий, ардын язгуур урлагийн 1805 хүүхдийн тоглолтуудыг бэлтгэн зохион байгуулж, ард иргэддээ тайлагнав.

МОНГОЛЫН ЗОХИОЛЧДЫН ЭВЛЭЛТЭЙ ХАМТРАН АЖИЛЛАЖ БАЙНА



Ном хөтөлбөрийн хүрээнд Монгол улсын шилдэг зохиолч, яруу найрагчдын уулзалтыг Ерөнхий боловсролын 24 сургуулийн сурагчдын дунд зохион байгуулж, давхардсан тоогоор 20000 гаруй хүүхдийг уг арга хэмжээнд хамрууллаа.

ХУВИЙН ХЭВШЛИЙН 11 ЦЭЦЭРЛЭГ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙНА

2014-2015 оны хичээлийн жилд 9 хувийн цэцэрлэгүүд шинээр нэмэгдэж, одоогийн байдлаар аймгийн хэмжээнд 11 хувийн цэцэрлэгт 395 хүүхэд сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээг хүртэх боллоо.



“НАСАН ТУРШИЙН БОЛОВСРОЛЫН ТӨВ” БАЙГУУЛАГДЛАА



Албан бус боловсролыг өргөтгөн “Насан туршийн боловсрол төв” болгож, барилгыг орон нутгийн хөгжлийн сангаас 30,0 сая төгрөгөөр засварлан, анги танхимыг тохижуулж, 2014 онд иргэдийн хөгжлийг дэмжих сургалтуудад 6798 хүнийг хамруулсан нь өмнөх оноос 29,6 хувиар өссөн байна.

“БАНУУН БҮСИЙН ХҮҮХДҮҮД” ЧУУЛГАН БОЛЛОО



Аймгийн Засаг даргын санаачилгаар “Баруун бүсийн хүүхдийн соёлын наадам, зөвлөлгөөн”-ийг 180 гаруй хүүхдийн төлөөлөлтэйгөөр зохион байгуулж, бүс нутгийн хэмжээнд хүүхдийн өмнө тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлж, Хүүхдийн төлөө үндэсний газарт хүргүүлэв.

АЙМГИЙН АХМАД БАГШ НАРЫН II ЗӨВЛӨЛГӨӨНИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАВ.



Аймгийн Засаг даргын санаачилгаар “Ахмад багш нарын II зөвлөлгөөнийг зохион байгуулж, 220 ахмад багш, боловсролын болон сургуулийн удирдах ажилтан 24, нийт 250 гаруй хүн оролцлоо.

“ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖИЛ МЭДЭЭЛЛИЙН ТӨВ” НЭЭГДЛЭЭ



Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтсийн дэргэд НҮБ-ын Хүн амын сан, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны дэмжлэгтэйгээр “Залуучуудын хөгжил мэдээллийн төв”-ийг 89,4 сая төгрөгийн өртөгтэй байгуулж, 2 оронтойгоор үйл ажиллагаа явуулж байна.

ЦААШИД 2014 ОНД ХИЙГДЭХ АЖЛУУД:

ЕБС-д суралцагчдад хүртээмжтэй, чанартай, хэрэгцээнд нь нийцсэн боловсрол эзэмших тэгш боломжийг бүрдүүлж, суурь боловсролын хамран сургалтыг 95.6 хувьд хүргэнэ.

Хөдөөгийн багуудад гэр цэцэрлэгүүдийг байгуулж, үйл ажиллагааг нь тогтмолжуулан, сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг 80.5 хувьд хүргэж, цэцэрлэг байгуулах, хүүхэд харах, асрах үйлчилгээ нээж ажиллуулахыг дэмжинэ.

Багшийн мэргэжил, арга зүйн хөгжил, ёс зүй, нийгмийн хамгааллын асуудлыг нь шийдвэрлэх зорилгоор “Багшийн хөгжил” дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.

Хүүхдийн авъяас, билгийг багаас нь нээн хөгжүүлэх зорилгоор “Зөв Монгол хүүхэд”, “Авъяас”, “Ном” хөтөлбөрийг бусад хөтөлбөрүүдтэй уялдуулан олон нийтийн оролцоонд тулгуурлан хэрэгжүүлнэ.

Үндэсний лаборатори сургуулийн үйл ажиллагааг бэхжүүлж, сургалтын дэвшилтэд технологийг орон нутгийн онцлогтой уялдуулан нэвтрүүлнэ.

Насан туршийн боловсрол төвийг байгуулж, үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэн иргэдэд амьдрах ухааны боловсрол олгох насан туршийн боловсролын нэгжийн үйл ажиллагааг тогтмолжуулна.

Сургууль, цэцэрлэг, соёлын байгууллагын мэдээлэл харилцааны технологийн тоног төхөөрөмжийн хангамжийг сайжруулж, цахим сургуулийн тоог нэмэгдүүлнэ.

Дотуур байрны үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж, Мөст Чандмань сумын дотуур байрыг ашиглалтанд оруулна.

Үенч, Чандмань, Жаргалант сумын I сургуулиудын барилгыг ашиглалтанд оруулна.

Цаст-Алтай цогцолбор, Буянт, Мөнххайрхан, Дарви сумын сургуулийн их засвар хийнэ.

Булган суманд цэцэрлэгийн барилгыг шинээр барьж, Жаргалант сумын Бичигт багт цэцэрлэг ашиглалтанд оруулна.

Бүс нутгийн байгалийн баялаг, хүн ардын түүх, соёлд холбогдох суурь судалгааны ажлыг өргөжүүлж “Баруун Монголын түүх соёл, байгалийн нөхцөл, нөөц ашиглалт” олон улсын эрдэм шинжилгээний хурал зохион байгуулна.

Аймаг, бүсийн түвшинд хэрэгжүүлж буй хөгжлийн бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын төслүүдтэй холбоотой хэрэглээний болон бодлогын судалгааг хэрэгжүүлж, орон нутгийн чадавхийг бүрдүүлнэ.

Залуучуудын хөгжлийн төвийн үйл ажиллагааг сайжруулж, мэдлэг, чадвартай, хариуцлагатай, өөртөө итгэх зан үйл бүхий амьдарлын ур чадвартай өсвөр үе, залуучуудыг төлөвшүүлэхэд анхаарч ажиллана.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг боловсролд тэгш, хүртээмжтэй хамруулж, мэргэшсэн багш нарыг үе шаттай бэлтгэнэ.